

**“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ПРОТОКОЛ**

2022 оны 04-р сарын 20-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт саналын эрхтэй энгийн хувьцааны

- (i) 77 хувь буюу 7,996,539 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигч “Хасвуу” ХХК,
- (ii) 18 хувь буюу 1,869,320 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигч С.Нэргүй нар
- (iii) 5 хувь буюу 519,256 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигч Хас Энержи ПиТиЕэ Лтд (Khas Energy Pte Ltd) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн байна.

Компанийн тухай хуулийн 83.8-д заасны дагуу Хасвуу ХХК-г итгэмжлэлгүй төлөөлөх этгээд нь түүний гүйцэтгэх захирал С.Нэргүй болох нь тус компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээгээр нотлогдож байгааг

иргэн С.Нэргүй нь тус хуралд өөрийн биеэр ирсэн болохыг түүний Монгол Улсын иргэний үнэмлэхээр нотлогдож байгааг

Хас Энержи ПиТиЕэ Лтд -ийг Ц.Хангай нь төлөөлөх эрхтэй этгээд болохыг холбогдох бичиг баримтаар нотолж байгааг тэмдэглэн

түүнчлэн С.Нэргүй нь 2021оны 05 дугаар сараас -2022 оны 04 сарыг дуустал ДСЦТС ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байгааг, Ц.Хангай нь ТУЗ -тэй байгуулсан гэрээний дагуу ДСЦТС ХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байгаа болохын мөн тэмдэглэн

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ын ирц 100 хувьтай бүрдсэн болохыг Хурлын дарга болон Компанийн хувьцаа эзэмшигчдэд мэдээлж байна.

Хурлын ажиллагаанд амжилт хүсье.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



М.Баярманла

М.БАЯРМАНЛА

Г.БЭХБАТ

**“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 04-р сарын 20-ны өдөр

Дугаар 22/01

Улаанбаатар хот

Хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид “Компани”гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 20-ны өдрийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр гэж тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.БАЯРБААТАР

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИСС**

2022 оны 4-р сарын 20 -ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Санал хураалтын дүнгийн тухай

Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани цаашид “Компани” гэх\-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 20-ны өдрийн ээлжит хурлаар Компанийн хувьцаа эзэмшигчдийн гаргасан саналыг шалгаж тоолсон дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гаргасан дүгнэлтийг /хэлэлцэх асуудал №1/ Компанийн саналын эрхтэй 10,385,116 ширхэг энгийн хувьцаа буюу нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 100 хувийг эзэмшигчид *сайшаан баталсан болохыг* Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдсүгэй.

Хоёр. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэх (хэлэлцэх асуудал №2) Компанийн саналын эрхтэй 10,385,115 ширхэг энгийн хувьцаа буюу нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 100 хувийг эзэмшигчид *сайшаан баталсан болохыг* Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдсүгэй.

Гурав. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох (хэлэлцэх асуудал №3)

(1) ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Цэндсүрэнгийн Баярбаатарын төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901.66 ширхэг санал буюу 11,11 хувь саналаа өгсөн болохыг,

(2) ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Лужаагийн Балганы төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901.66 ширхэг санал буюу 11,11 хувь саналаа өгсөн болохыг,

(3) ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Галсангийн Бэхбатын төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901.66 ширхэг санал буюу 11,11 хувь саналаа өгсөн болохыг,

(4) ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Нүдэнгийн Эрдэнэбатын төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901.66 ширхэг санал буюу 11,11 хувь саналаа өгсөн болохыг,

(5) ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Энэбишийн Долгорсүрэнгийн төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901.66 ширхэг санал буюу 11,1 хувь саналаа өгсөн болохыг,

(6) ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Самдангийн Нэргүйн төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901.66 ширхэг санал буюу 11,1 хувь саналаа өгсөн болохыг,

(7) ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Буянзаяагийн Эрдэнэбилгийн төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901.66 ширхэг санал буюу 11,1 хувь саналаа өгсөн болохыг,

(8) ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Түмэнжаргалын Энхмэндийн төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901.66 ширхэг санал буюу 11,1 хувь саналаа өгсөн болохыг,

(9) ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Цэнгэлийн Хангайн төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901.66 ширхэг санал буюу 11,1 хувь саналаа өгсөн болохыг,

тус тус Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдсүгэй.

Дөрөв. Компанийн ТУЗ болон түүний гишүүдийн 2022.05.01-2023.04.30-ний өдөр хүртэлх цалин урамшуулал болон зардлыг батлах (хэлэлцэх асуудал №4) тухай Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төслийг Компанийн саналын эрхтэй 10,385,115 ширхэг энгийн хувьцаа буюу нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 100 хувийг эзэмшигчид сайшаан баталсан болохыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



ГИШҮҮН

М.БАЯРМАНЛА

Г.БЭХБАТ

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 4 -р сарын 20-ны өдөр

Дугаар 22/02

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дахь заалт, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх
Сүлжээ Хувьцаат Компани (цаашид “Компани”гэх) -ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны
04-р сарын 20-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссийн дүнг үндэслэн ТОГТООХ
нь:

Нэг. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг сайшаан баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.БАЯРБААТАР

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 04-р сарын 20

Дугаар 22/02

Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүдийг сонгох
болон ТУЗ-ийн зардлын төсвийг
батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид "Компани"гэх) -ийн Дүрмийн 7-р зүйлийн 7.8.7 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 20-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссийн дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнээр сонгож баталсугай.

Хараат бус гишүүд:

- (i) Цэндсүрэнгийн Баярбаатар
- (ii) Лужаагийн Балган
- (iii) Галсангийн Бэхбат

Ердийн гишүүд:

- (iv) Нүдэнгийн Эрдэнэбат
- (v) Цэнгэлийн Хангай
- (vi) Түмэнжаргалын Энхмэнд
- (vii) Самдангийн Нэргүй
- (viii) Энэбишийн Долгорсүрэн
- (ix) Буянзаяагийн Эрдэнэбилэг

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.БАЯРААТАР